

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудасны дугаар</b>
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-30
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	31-122
	1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2018.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	31-51
	2.“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	52-72
	3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	72-92
	4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	92-94
	5.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/	94
	6.“Хууль баталсантай холбогдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”, “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд	94-104
	7.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	104-106
	8.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	106-110
	9.Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	110-114
	10.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.01.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	114-120
	11.Ажлын хэсэг байгуулах тухай /Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай/	120-122

#### **Хураангуй тэмдэглэл**

***Найм.Зохлогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн А.Амармөрөн, Оюуны өмчийн газрын дарга Б.Энхсүх, мөн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг, Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэлтсийн дарга С.Урангэрэл, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Одгэрэл, Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны гишүүн Д.Нэргүй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Золжаргал, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Төслийн үзэл баримтлалын талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Д.Эрдэнэчимэг нар хариулж, тайлбар хийв.

**С.Бямбацогт:** Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

### **Дэлгэрэнгүй тэмдэглэл**

**Найм.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлэг явуулъя.**

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Нямбаатар гишүүнийг микрофонд урьж байна.

**Х.Нямбаатар:** Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал анх 1993 онд Зохиогчийн эрхийн тухай хуулийг баталсан бөгөөд зохиогчийн эрхийн олон улсын гэрээ, конвенц болон нийгэм, эдийн засгийн харилцааны шинэчлэлтэй уялдуулан 2006 онд Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль болгон шинэчлэн найруулгыг баталсан байна.

Гэвч хуулийг хэрэгжүүлэх явцад оюуны бүтээлийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй ашиглах, хуулбарлах, хууль бусаар орлого олох явдал эрс өсөн нэмэгдэж, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зохицуулалтыг боловсронгуй болгох, цахим болон харилцаа холбооны бусад сүлжээ, өргөн нэвтрүүлэг, олон суваг дамжуулагч, дуу хөгжим, дуу авиа бүхий дүрст бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, зохиогч, эрх эзэмшигчийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг нарийвчлан тодорхойлох шаардлага үүсээд байна.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дор дурдсан шинэлэг зохицуулалтыг тусган боловсрууллаа.Үүнд:

1.Зохиогчийн эрхийн хамгаалалтын хугацааны хувьд гэрэл зураг болон хавсарга уран бүтээлийг ашиглах онцгой эрх нь уг бүтээлийг туурвисан өдрөөс эхлэн 25 жилийн хугацаанд, кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээл ашиглах онцгой эрх нь

бүтээлийг анх нийтэлсний дараа жилийн 1 дүгээр сарын 1- нээс эхлэн 50 жилийн хугацаанд, бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээгээр хуулийн этгээдэд шилжүүлэх тохиолдолд бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээл нийтлэгдсэний дараа жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 50 жилийн хугацаанд тус тус хамгаалагдахаар тусгах.

2.Зохиогчийн эрхийн зөвшөөрөл шаардагдахгүй байх онцгой нөхцөлийг буюу бүтээлийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зүй ёсны ашиглалттай зөрчилдөхгүйгээр, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөлгүйгээр бүтээлийг төлбөргүйгээр болон зөвшөөрөлгүйгээр ашиглах тохиолдлуудыг нарийвчлан тодорхойлох. Түүнчлэн бүтээлийг төлбөргүйгээр болон зөвшөөрөлгүйгээр ашиглах “шударга ашиглалт”-ын нөхцөлийг тодорхойлсон.

3.Үүсмэл бүтээл, албан үүргийн дагуу туурвисан бүтээл, кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээл, компьютерын программ, мэдээллийн сан, дүрслэх урлагийн бүтээл, архитектурын бүтээлийн зохиогчийн эрхийг онцлогийг дэлгэрэнгүй тусгах.

4.Бүтээл ашиглах онцгой эрхийг шилжүүлэх, эсхүл бүтээл ашиглах онцгой эрхийг лиценз олгох замаар бусдад бүтээл ашиглуулах үндсэн арга хэлбэрийг тодорхойлсон. Түүнчлэн бүтээл ашиглах эрх шилжүүлэх гэрээ болон лицензийн гэрээний үндсэн нөхцөлийг нарийвчлан тусгах.

5.Цахим орчноос гадна харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах, бүтээлийг зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахаас урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээний талаар нэмж тусгах.

6.Зохиогч, эрх эзэмшигчдийн эрхээ төлөөлүүлэн хэрэгжүүлэх, хамгаалуулах үндсэн хэлбэр болох хамтын удирдлагын байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосон. Тодруулбал хамтын удирдлагын байгууллагад тавих шаардлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаандаа ил тод, шуурхай байдал болон үнэн зөв, бодит мэдээллийг хангаж ажиллах эрх зүйн орчныг бий болгож, уг харилцаанд оролцогчдын эрх, ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах боломжийг бүрдүүлэх.

7.Хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хараагүй, сонсголгүй, харааны, эсхүл сонсголын бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан тэдний хүртэж болох хэлбэрт шилжүүлэн хуулбарлах, хуулбарыг хил дамнуулан солилцох, нийтэд түгээх болон нийтийн хүртээл болгоход зохиогчийн эрхийг хязгаарлахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгах.

8.Цахим орчноос гадна харилцаа холбооны бусад сүлжээнд зохиогчийн эрхийг хамгаалах, бүтээлийг зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахаас урьдчилан сэргийлэх технологийн хамгаалалтын арга хэмжээний талаар нэмж тусгах.

9.Бүтээл ашиглалтын тарифыг хянаж батлах чиг үүрэг бүхий Зохиогчийн эрхийн зөвлөлийг байгуулах эрх зүйн үндэслэлийг тодорхойлох. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төслийг боловсруулах ажлын үе шатын дагуу хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооны тайлан судалгааг тус тус хийлгэж, хуулийн төсөлд саналыг тусгасан.Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн

болон төрийн бус байгууллага, судлаачдаас санал авч саналыг тусгасан. Түүнчлэн хуулийн төслийг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас хэрэгжилтийг нь хангадаг Олон улсын гэрээ конвенцод нийцэж байгаа эсэх талаар Дэлхийн Оюуны Өмчийн газрын Олон улсын товчооноос урьдчилсан санал авч, хуулийн төсөлд саналыг тусгасан болно.

Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал хуулийн төслийг дэмжиж Улсын Их Хурлаар чуулганаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Нямбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Ажлын хэсэг Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яам, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яам. Энхсүх Оюуны өмчийн газрын дарга, Ганзориг Оюуны өмчийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Оюуны өмчийн газрын Оюуны өмчийн хяналтын хэлтсийн дарга, Урангэрэл Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хэлтсийн дарга. Амармөрөн Хууль зүй, дотоод хэргийн яам Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Эрдэнэчимэг Отгонтэнгэр их сургууль, Одгэрэл итгэмжлэгдсэн төлөөлөгч оюуны өмчийн, Нэргүй Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч холбооны гишүүн.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд байна уу? Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

**Б.Энх-Амгалан:** Би 2 л асуулт асууя. Энэ зохиогчийн эрхтэй холбоотойгоор ялангуяа энэ Өвөр монголд манай зохиолчдын номуудыг чинь Монгол бичгээр хэвлэдэг, орчуулдаг, өөр нэрээр гаргадаг ийм тохиолдол бол хэд хэд гарсан юм. Тэгээд дууг нь хувилдаг дагаж дуулдаг. Биелгээг нь дагаж биелдэг энэ тэр гээд. Тэгэхээр энэ зохиогчийн эрх гадаадад зөрчигдвөл яах вэ. Ийм тохиолдолд яаж хамгаалах вэ гэж нэг асуулт асуумаар байгаа юм.

2 дахь нь ардын дуу, ардын бүжиг, уртын дуу энэ хөөмий магтаал ерөөл биелгээ энэ домог үлгэр энэ уул овоо тахих ёслол бэр гуйх ёслол гээд одоо ингээд Монголын үндэсний нэг тийм бахархал болсон зан үйл байна шүү дээ. Галын тахилга ч гэдэг юм уу. Эд нарыгаа одоо яаж хамгаалах вэ. Манайхан чинь очоод тэндээ очиж зааж өгөөд байдаг юм байна лээ. Бүжиг биелээч, дэглээч нь очоод бүжгээ зааж өгдөг, зохиолчид нь очиж юмаа зааж өгөөд. Дуучид нь очиж дуугаа зааж өгөөд. Хамтлагууд нь очиж хөгжмөө зааж өгөөд байдаг. Тэгэхээр энийг яах юм бэ? Тэгээд тэрнээсээ болоод их олон тийм хүн амьтан бүжиглэдэг барьдаг юмаа тэгээд дэлхийн тэр нөгөө соёлын өвд бүртүүлчихдэг гээд яваад байдаг юмнууд байдаг юм шиг байгаа юм. Энийгээ яаж зохицуулах вэ гэж би асуух гээд байна.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Сайнзориг 4 дүгээр микрофон.

**П.Сайнзориг:** Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултаас нь хариулъя. Мэдээж бас таны хөндөж тавьж байгаа асуудал бол чухал асуудал байгаа

юм. Ардын урлаг бас энэ өв соёлын асуудлыг хэрхэн яаж хамгаалах вэ, цаашдаа бас энэнээс олох үр ашгийг бас нийт ард түмэнд ч гэдэг юм уу Монголын ард түмэнд хүртээх энэ асуудал бол зайлшгүй байгаа. Яг энэ хуулийн хүрээнд бол уг асуудал бол хөндөгдөхгүй байгаа. Өөрөөр хэлэх юм бол бас энэ ардын урлаг гэдэг юм уу энэ өв соёлтой холбоотой зүйлийн зохиогч нь хэн бэ гэдэг асуудлаас эхлээд маргахаар яг зохиогчийн эрхийг хамгаалах тухай хуульд бол байхгүй.

Харин цаашдаа бид нар бол тухайлсан хуулийг гаргах яах вэ ерөнхий суурь зохицуулалтууд бол байгаа. Мэдээж Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бусад хуулиудаар ингээд зохицуулалтууд байгаа боловч цаашдаа үүнийгээ илүү их тодруулж бас энэ ардын урлагийг хамгаалах энэтэй холбоотой бас асуудал тийм ээ ашигласан тохиолдолд үр шимийг нь одоо хүртээх язгуур урлагуудын энэ асуудлыг хамгаалах асуудлыг бас тухайлан хууль гаргаж асуудлуудыг бас Хууль зүй, дотоод хэргийн бас судалж байгаа гэдэг зүйлийг хэлье.

2 дугаарт энэ хил дамнасан энэ асуудлууд байгаа бас. Бас энэ оюуны өмчийн салбарын бас нэг онцлог байгаа л даа. Ерөнхийдөө Монгол Улсад бүртгүүлсэн аж үйлдвэрийн болон энэ ер нь зохиогчийн эрхтэй холбоотой энэ өмчийн асуудлуудыг хамгаалалтыг нь нэгэнт одоо зохиогчийн эрх үүссэн энэ асуудал дээр бас хилийн чанадад буюу хамгаалуулах асуудлыг нь олон улсын гэрээ конвенцоороо бол зохицуулагдах бүрэн боломжтой буюу тухайлан таны дурдсан БНХАУ-д зохиогчийн эрхийн асуудал үүсэх юм бол манай оюуны өмчийн байгууллага болоод холбогдох бусад шугамаар тухайн одоо БНХАУ-ын оюуны өмчийн байгууллагад хандаж бас энэ зохиогчийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлаа шийдвэрлүүлэх ийм боломж бол байгаа. Ийм байдлаар одоо цаашдаа асуудал бол хандаад явах ийм гарц байгаа.

Энийг ч гэсэн энэ хуулиар нэлээн бас тодруулж өгч байгаа. Мөн бас 20 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан оюуны өмчийн тухай хуулиар бас оюуны өмчийн байгууллагын чиг үүрэг нэлээдгүй бас тодорхой болж өгсөн. Тэгээд энэ асуудлыг бас цаашдаа анхааръя.

**С.Бямбацогт:** Энх-Амгалан гишүүн тодруулъя.

**Б.Энх-Амгалан:** Энэ уртын дууны чинь үргэлжлэл ардын дуу, ардын дууны чинь үргэлжлэл зохиолын дуу л юм байгаа л даа. Тэгээд энэ одоо үндсэн бид нар ардын дагуу, ардын бүжиг, уртын дуу, ерөөл магтаал хөөмий биелгээ домог үлгэр магтуу гээд энэ олон юмнуудаа энэ амьтныг тахидаг манайхан чинь тийм ёслолтой шүү дээ. Тэгээд энийгээ зохиогч нь тодорхой биш юм уу тэгээд энэ одоо яах дараа нь больё гэдэг юм байж болдог юм уу. Бид нар чинь дээлээ хүртэл аваачаад өөр улсын нэр дээр гадна талд бүртгүүлчихсэн биз дээ. Тэгээд энэ чинь бидний үндсэн өв соёлын эх булаг нь байхгүй юу. Ийм эх булгийгаа одоо энэ бол энэ дээр зохицуулагдахгүй. Зохиогч нь тодорхой биш учраас гэж ярьж болдог юм уу бид нар. Тэгээд тэр гадна талд хамгаалахдаа яах юм бэ? Ямар байдлаар хамгаалах юм бэ? Тэр хүмүүс одоо хэрэв хувилаад олшруулсан бол эргэж нөхөн төлбөр олгох юм уу, яах юм бэ энэ хоёр дээр.../минут дуусав/

**С.Бямбацогт:** 1 дүгээр микрофон. Ажлын хэсэг хариулъя.

**Д.Эрдэнэчимэг:** Сайн байцгаана уу Эрдэнэчимэг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны тэргүүн. Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал байна. Таны асуусан асуултад хариулахад зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль гээд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа зохиогчийн эрхийн тухай хууль дээр ардын урлагийн бүтээл бол зохиогчийн эрхээр хамгаалагдахгүй гээд тов тодорхой заасан байдаг. Энэ нь Монгол Улсын нэгдэж орсон олон улсын Венын конвенц дээр бас ардын урлагийн бүтээлийг хамгаалах эсэх нь тухайн одоо дотоодын орны хууль тогтоомжоор зохицуулагдана гэж заасан байдагтай холбоотой байдаг.

Одоо энэ шинэчилж орж ирж байгаа хууль дээр бид нар ямар сайжруулалт хийж байгаа вэ гэхээр ардын урлагийн бүтээл бол тухайн зохиогчийн эрхээр хамгаалагдаж байгаа бүтээлийг хамгаалах 1 дүгээрт хугацаа дууссан байдаг. 2 дугаар зохиогч нь тодорхойгүй байдаг гэдэг шалтгаанаар хамгаалахгүй гэсэн зохицуулалтаа үүрэгжүүлнэ. Гэхдээ тухайн ардын урлагийн бүтээл дээр тулгуурлаад үүсмэл бүтээл туурвих юм бол тэр ардын урлагийн бүтээлийг өөр хэлбэр рүү оруулах юм бол тэр үүсмэл бүтээл туурвисан.../минут дуусав/

**С.Бямбацогт:** Сунгая ажлын хэсэг. 1 номерын микрофон сунгаад.

**Д.Эрдэнэчимэг:** Тэгээд Монгол Улс бол дэлхийн оюуны өмчийн байгууллагаас батлан гаргасан утга зохиол урлагийн бүтээлийг хамгаалах тухай Венын конвенцид нэгдэж орсон байдаг. Энэ Венын конвенцын дагуу тухайн Венын конвенцын гишүүн орнуудад Монгол Улсын иргэний зохиосон зохиогчийн эрхийн бүтээл бол бүгд хамгаалагддаг байгаа. Тэгэхээр зохиогчийн эрх нь Хятадад зөрчигдөөд байгаа тухайн эрх нь зөрчигдөөд байгаа зохиогч маань хятад улсад хандаад оюуны өмчийн газарт нь хандаад эрхээ хамгаалуулах бол бүрэн боломжтой байдаг.

Хэрэв Хятад Улсын иргэний зохиогчийн эрх Монгол Улсад зөрчигдөх юм бол тухайн Хятад Улсын иргэн бас Монгол Улсад оюуны өмчийн газарт хандаад эрхээ хамгаалуулах бүрэн боломжтой байгаа. Энэ нь бол олон улсын гэрээ конвенцоор бол зохицуулагдсан байдаг.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Санал хураалт явуулъя. Хуулийн төслийн үзэл баримтлалыг төслийнх хүрээнд дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 6 гишүүн буюу 54,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаар санал хэлэлцүүлэг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Сандаг-Очир гишүүн танилцуулчих уу? Сандаг-Очир гишүүн. Тэгье. Дараагийн асуудалдаа оръё.